

## 3.5 Хариуцсан анги бүлгийн мэдээлэл

Багшийн хариуцсан анги, бүлгийн мэдээлэл оруулах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. **БУ системийн Багш** үйл ажиллагааг сонгоно.
2. Багшийн жагсаалтаас хариуцсан анги, бүлгийн мэдээлэл оруулах багшийн нэрийг сонгоно.
3. Үйлдэл цэсээс **багшийн мэдээлэл** үйлдлийг дарна эсвэл жагсаалтаас багшийн нэр дээр дарна.
4. Багшийн мэдээлэл цонхноос Хариуцсан анги, бүлэг цэс рүү орно.
5. Мэдээлэл засах товч дарна.
6. Бүлэг нэмэх товч дарна.

Д/д	Анги, бүлэг	Хариуцсан үүрэг	Эхлэх огноо	Үндсэн багш
1	6-г	Анги удирдсан багш	2018-04-12	<input checked="" type="checkbox"/>

### Анги бүлэг

**Анги бүлэг** хэсэгт бүлэг үүсгэх үед тухайн багшийг **хариуцсан багш (АУБ)** хэсэгт тодорхойлсон бол багшийн мэдээллийн хариуцсан анги, бүлэг мэдээллийн хэсэгт хариуцсан ангийг шууд харуулна. Жич: Ахлах бүлгийн АУБ-ийг шууд харуулна.

### Хариуцсан үүрэг

**Анги бүлэг** хэсэгт бүлэг үүсгэх үед тухайн багшийг **хариуцсан багш** хэсэгт тодорхойлохдоо хариуцсан үүргийг тодорхойлсон бол **хариуцсан үүрэг** талбарт тухайн үүрэг харагдана. Жишээ нь: анги удирдсан багш, туслах багш гэх мэт.

### Эхлэх огноо

Анги хариуцаж эхэлсэн болон эхлэх огноог оруулж өгнө.